

МУ-ЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

БАТЛАВ.

А.ЗАНГАД

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд						
№	Хийх ажлын агуулга	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах газар	Хамтран хариуцах	Хүрэх үр дүн
1	Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэр, бодлогын баримт бичгийн төслийг цахим хуудаст байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх, бололцоо нөхцөлөөр хангах	Төрийн аудиттай холбоотой УИХ-аар хэлэлцэгдэх хууль, бусад шийдвэр, бодлогын баримт бичгийн төслийг цахим хуудаст байршуулж, төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авах /цахим хуудсаар, санал асуулга/, судлах, хариу мэдэгдэх	Тухай бүр	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Хууль, шийдвэр, баримт бичгийн төсөлд санал авч, тусгасан байх
2	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж АТГ-т хүргүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах	Жилдээ	Тамгын газар	Ерөнхий менежер	Төлөвлөгөөг заасан хугацаанд батлуулж АТГ-т хүргүүлсэн, хэрэгжүүлсэн, хугацаанд нь тайлагнасан байна
		Төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалтад хамруулах	2, 6, 7, 8 дугаар саруудад	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Албан хаагчдын хуулийн мэдлэгийн түвшин ахисан байх
		Албан тушаалтны хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлгийг тухай бүр авч, дүгнэлт гаргуулан албан тушаалд томилох эсэх асуудлыг шийдвэрлэх	Жилдээ	Тамгын газар		Хувийн ашиг сонирхлыг урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хүргүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

2	<p>Ажилтнуудад Авлигатай тэмцэх хууль тогтоомж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд авч, АТГ-т хүргүүлэх, тайлагнах</p>	3 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хуульд заасан хугацаанд мэдүүлгийг АТГ-т хүргүүлж, тайлагнасан байна.
	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн сурталчилгааны материалыг бүртгэн хүлээн авч, түгээсэн талаарх бүртгэл хөтлөх</p>	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хуулийг хэрэгжүүлж бүртгэл хөтөлсөн байна.
	<p>Авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр Аймаг, Нийслэлийн аудитын газарт чиглэл зөвлөмж өгөх</p>	4 дүгээр сард	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Хууль хэрэгжүүлж ажиллах соёл бий болж, хэвшсэн байна.
	<p>Төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод, олон нийттэй харилцах журам боловсруулах, хэрэгжилтийг хангах</p>	3 дугаар сард	Тамгын газар		Төрийн аудитын байгууллагын мэдээллийн ил тод байдал хангагдсан байна.
	<p>Төрийн аудитын төрөлжсөн болон Аймаг, Нийслэлийн аудитын газруудын нэг ажилтанд хэвлэл мэдээллийн асуудлыг хариуцуулах</p>	3 дугаар сард	Тамгын газар		Хэвлэл мэдээллийн асуудлыг хариуцуулсан байна.
	<p>Харилцагч байгууллагуудтай хийх гэрээнд ёс зүй, сонирхолын зөрчлөөс сэргийлэх талаар тусгах</p>	Тухай бүр	Газрууд		Гэрээ бүрт заалт туссан байна.
	<p>Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг цахим хуудсанд хуулийн дагуу тогтмол байршуулж, мэдээллийг шинэчлэх</p>	Тухай бүр	Тамгын газар	Бусад газрууд	Цахим хуудаст тухай бүр шинэчилж байршуулсан, цаг үеийн тогтмол мэдээллээр хангагдсан байна.

3	Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм, журмыг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх	Авлигын эсрэг хууль тогтоомж, дүрэм журмыг цахим хуудас болон мэдээллийн самбарт шинэчилж байршуулах, иргэд, байгууллага чөлөөтэй татаж авах нөхцөлөөр хангах	3 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Мэдээллийн урсгал уялдсан холбоо сайжирна.
4	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	ҮАГ-ын 2014 оны жилийн төлөвлөгөөг цахим хуудаст байршуулах	2 дугаар сард	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Цахим хуудаст тухай бүр байршуулсан байна.
		Аудитын тайланг баталгаажуулснаас хойш нууцын зэрэглэлтэйгээс бусад тайланг тухай бүр цахим хуудаст тогтмол байршуулж байх	Тухай бүр	Тамгын газар	Төрөлжсөн болон Аймаг, нийслэлийн аудитын газрууд	
		Аудитын үйл ажиллагаа, акт, албан шаардлага, биелэлтийн талаар тогтмол цахим хуудаст байршуулж, мэдээлж байх	Тухай бүр	Тамгын газар	Төрөлжсөн болон Аймаг, нийслэлийн аудитын газрууд	
5	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх	2014 оны төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ны дотор/, 2015 оны төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны өдрийн дотор/, Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр /4 дүгээр сарын 1-ны өдрийн дотор/, Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл /өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор/, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг /тухай бүр /цахим хуудаст байршуулах, тухай шинэчлэх	Тухай бүр заасан хугацаанд	Тамгын газар		Төсвийн нээлттэй, тунгалаг байдал, төсвийн сахилга батыг хангасан байна.
		Тухайн жилд төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цахим хуудсаар мэдээлэх	Жилдээ	Тамгын газар		Мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг хэвшүүлсэн байна.

		Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл, хэрэгжилт, хөрөнгийн хуваарилалтыг цахим хуудаст байршуулах	Жилдээ	Тамгын газар	
6	Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах	Санхүүгийн аудитыг гэрээгээр гүйцэтгүүлэх, сонгон шалгаруулах журам, гэрээний төслийг цахим хуудаст байршуулах	Жилдээ	САГ	Олон нийт бүрэн мэдээллээр хангагдсан байна.
		Санхүүгийн аудитыг гэрээгээр гүйцэтгэх байгууллагын сонгон шалгаруулалтыг цахим хуудсанд байрлуулах, нийтэд зарлах	Тухай бүр	САГ	
		Гэрээт аудит хийхээр сонгон шалгарсан байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар, гүйцэтгэх ажлын жагсаалтыг цахим хуудаст байрлуулах	Тухай бүр	Тамгын газар	
7	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах	Сул орон тоог нийтэд мэдээлж, ажилтныг сонгон шалгаруулалтын журмын дагуу зохион байгуулах	Тухай бүр	Тамгын газар	Сул орон тоог нийтэд мэдээлсэн, холбогдох журмын дагуу сонгон шалгаруулсан байна.
		2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, цахим хуудаст байршуулах	төсөв батлагдсанаас 1 сарын дотор	Тамгын газар	Төлөвлөгөөг заасан хугацаанд цахим хуудсанд байршуулсан байна.
		Бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарыг цахим хуудас, хэвлэл мэдээллээр хугацаанд нь мэдээлэх	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд

8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчдын талаарх мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөлийн талаар танилцуулах, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлэх, Худалдан авсан бараа ажил, үйлчилгээний тайланг цахим хуудасд байршуулах,	Тухай бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна.
		Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдэгдэх	Тухай бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Илэрсэн зөрчлийг тухай бүр мэдэгдэж, арилгасан байна.
		Үнэлгээний хороонд сонирхолын зөрчилгүй хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байна.	Тухай бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байна.
9	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Албан хаагч бүрийн хариуцсан ажил үүргийн талаарх мэдээллийг нээлттэй болгох	3 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудаст байршуулсан байна.
		Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулах	2 дугаар сард	Тамгын газар	Стратеги удирдлагын газар	Чиг үүрэг, ажлын давхардал арилсан, хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн байна.
10	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх	Эрх бүхий албан тушаалтныг Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамруулах	Тухай бүр	Тамгын газар		Зохион байгуулагдсан сургалтад бүрэн хамруулсан байна.
		Ашиг сонирхолын зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах нөхцөл бүрдүүлэх /цахим хуудсанд энэ талаар байршуулж, тогтмол утас ажиллуулах, шуудангаар авах/	2 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудаст байршуулсан байна.
		Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон өөрчлөлтийг сурталчлах	2 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хуульд орсон өөрчлөлтийн талаар албан тушаалтнууд мэдээлэл авсан байна.

11	Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Ашиг сонирхолын зөрчлийн талаар бүртгэл хөтөлж, хянан шийдвэрлэх	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Ашиг сонирхолын зөрчлийг бүртгэж, хянан шийдвэрлэсэн байна.
		Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгасан байх	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангаж ажилласан байна.
		Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж, гарын үсэг зуруулсан байна.	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Бүх албан хаагчид ёс зүйн дүрэмтэй танилцсан байна.
12	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Хууль болон УИХ-аас зөвшөөрсөн давхар ажил эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулах, давхар ажил эрхлэх зөвшөөрөл олгох	4 дүгээр сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Жагсаалт гаргаж, албан хаагчдад танилцуулсан, холбогдох зөвшөөрлийг олгосон байна.
13	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн илтөд, нээлттэй байдлыг хангах	Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудсанд байршуулах, шинэчлэх	Тухай бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудсанд шинэчлэн байршуулсан байна.
		Төрийн аудитын байгууллагын чиг үүрэг, эрхлэх асуудлын хүрээг шинэчлэн цахим хуудсанд байршуулах	4 дүгээр сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудсанд шинэчлэн байршуулсан байна.
14	Иргэдийн өргөдөл, /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч, шалгах	Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, барагдуулах	Тухай бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариу өгсөн байна.
		Олон нийттэй харилцах ажилтны нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг гаргаж, цахим хуудсанд байршуулах	3 дугаар сард	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудсанд шинэчлэн байршуулсан байна.
		Иргэдийн өргөдөл, (санал, мэдэгдэл) гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн байдлыг улирал бүрээр гаргаж, цахим хуудаст байршуулах	Улирал бүр	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Цахим хуудсанд шинэчлэн байршуулсан байна.

15	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	Авлигад төх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн гаргах, жагсаалт гаргахдаа судалгаанд суурилах	4 дүгээр сард	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Жагсаалтыг судалгаанд суурилж гаргасан байна.
16	Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлж байх	Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг АТГ-т мэдэгдэж, шалгуулж байх	Тухай бүр	Аудитын газрууд		Илэрсэн зөрчил бүрийг АТГ-т мэдэгдэж, шалгуулсан байна.
		Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан тоот, зөвлөмж, шаардлагыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд барагдуулах, шийдвэрлэх, хамтран ажиллах	Тухай бүр	ҮАГ, түүний харьяа газрууд		Албан тоот, зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажилласан, бүртгэл хөтөлсөн байх
Авлигаатай тэмцэх санал, санаачлага						
17	Албан хаагчдын шудрага байдал ба түүнийг нэмэгдүүлэх	Дотоод аудит, хяналтын тогтолцоог бүрдүүлэх	2 дугаар сард	Стратеги удирдлагын газар		Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.
18	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	Авлигын эсрэг арга хэмжээнд хөрөнгө зарцуулах, санхүүжүүлэх	Жилдээ	Тамгын газар	Аймаг, нийслэлийн аудитын газрууд	Авлигын эсрэг арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна.
		Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачлага, /уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м/-ыг дэмжиж оролцох	Жилдээ	Стратеги удирдлагын газар	Тамгын газар	Зохион байгуулагдсан үйл ажиллагаанд нэгдэж, дэмжиж оролцсон байна.

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:



Э.ОТГОН /ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР/

БОЛОВСРУУЛСАН



Л.ДУЛМАА /ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА/

С.СУГАРМАА /ШИНЖЭЭЧ, ХУУЛИЙН ЗӨВЛӨХ/